

## ШУА-ИЙН ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ХАМТ ОЛОНД

Миний бие 1979 онд МУИС-ийн Хэл бичгийн факультетийн Хятад судлалын ангийг хятад судлаач мэргэжлээр төгсгөснөөс хойш тус хүрээлэнтэй ажил төрөл, мэргэжил, мэдлэг, сонирхлоороо холбогдож, даруй 29 жилийг ардаа үдэж, эдүгээ хагас жарныг элээжээ. Хагас жаран гэдэг бол бага биш хугацаа, бас ч үгүй их ажил амжуулдаг цаг. Эргээд харахнаа би энэ хүрээлэнгийн 40 жилийн ойн баяр ёслолд эрхбиш уригдах, уригдлаа ч зочдын дотор араар зогсох эгэл нэгэн биш болов уу хэмээн бодож энэхүү баярын цахилгаанаа бичиж байна.

Тус хүрээлэнг 1960-аад оны эхээр ШУА дөнгөж байгуулагдсаны дараа хэлтэс нэртэйгээр байгуулж даргаар нь нэрт дипломатч Сономын Аварзэдийг томилон ажиллуулж байсан түүхэн тэр цагаас хойш төд удалгүй томсгож, 1970-аад онд “Дорно дахины судлалын хүрээлэн” нэртэй томхон хүрээлэн болгон төвхнүүлж төлөвшүүлсэн билээ. Олон улсын харилцаа, гадаад бодлого, аюулгүй байдлын тулгуур асуудлаар судалгаа хийдэг өөр байгууллага, хүрээлэн тухайн цагтаа Монголд байгаагүй, одоо ч олноороо зэрэгцээд байж байгаа биш тул тус хүрээлэнгийн 40 жилийн ойг зөвхөн ШУА бус, манай улсын нийт эрдмийн хүрээнийхэн, нийгмийн оюунлиг давхаргынхан нийтээрээ хамтран тэмдэглээсэй гэж би хүсч байна.

Тухайн цагийн улс төрийн бодлогод захирагдан харгис маоизмын эсрэг судалгаа, сурталчилгаа эрхлэх явцуухан хүрээтэй байсан тус хүрээлэн эдүгээ глобал болон бүс нутгийн бараг бүх асуудлаар цогц судалгаа хийдэг, гадаад өргөн харилцаатай, хэвлэлийн баазтай, нэр хүндтэй эрдэм шинжилгээний томхон төв болж чадсанд хүрээлэнгийн судлаач-профессорын хувьд сэтгэл нэн өег явдаг юмаа. Тус хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлж байсан “Дорно дахины судлалын асуудал” сэтгүүлийн 1980 оны 3 дугаарт “Маоизмын хувьслын зарим асуудал” сэдвээр эрдэм шинжилгээний анхны өгүүлээ нийтлүүлж байснаас хойш тус сэтгүүл болон түүний залгамжлагч “Дорно-Өрнө”, “Олон улс судлал”, англи хэл дээрхи “*The Mongolian Journal of International Affairs*” сэтгүүлд олон арван бүтээлээ хэвлүүлж, “Евразийн геополитик, олон улсын харилцаа: Өнгөрсөн, одоо, ирээдүй” судалгааны зохиолоороо тус хүрээлэнгийн судлаач-профессор хэмээх эрдмийн эрхэм цол хүртэж байсандаа үнэхээр бахархаж байдгаа энэ баярт мөчид илэрхийлье.

Хүрээлэнгийн тэгш 40 жилийн түүхт ой тохиож байгаа энэ баярт үйл явдлыг тохиолдуулан мэргэжил нэгт эрдэмтэд профессорууд Та бүхэндээ эрдэм бүтээлийн дээдийг хүсэн ерөөж, номын үйлс тань арвижих болтугай хэмээн бэлгэшээе!

Та бүхэнтэй хамтран баярлаж суугаа,

Профессор Олхонуд Д.Баярхүү Монгол Улсаас  
АБНУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд